

**“ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЭХНИЙ ҮЕ ШАТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2024.06.04

Шивээговь сум

Д/д	№	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Биелэлт	Хувь
ДӨРӨВ.ХОТ, ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ					
Зорилт 4.2.Шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулна.					
1.	4.2.6	Орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ, хүн амын төвлөрлийг бий болгохын тулд инженерийн дэд бүтцийг барьж байгуулах	Орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ бий болж, ажлын байр нэмэгдэж, шилжилт хөдөлгөөн буурсан байна.	Сумын хэмжээнд 2024 оны байдлаар УТХО-аар 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил, ЕБС-ийн 320 хүүхдийн сургуулийн барилгын ажлууд төсөвт тусгагдан хийгдэж, үйлчилгээний зориулалттай хувийн 2 ААН барилгын ажлыг гүйцэтгэж байна. 2024 он гарснаар суманд 62 иргэн шилжин ирээд байна. Хүрсэн түвшин: Түр ажлын байр 22	80
2.	4.2.7	Орон нутагт шилжсэн болон суурьшиж байгаа иргэн, өрх, хөдөлмөр эрхлэгчдийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн дэд бүтцээр хангагдсан орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх	Бүсчилсэн хөгжлийн бодлого болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хөдөө, орон нутагт хот суурин газрыг хөгжүүлэн Улаанбаатар хотын төвлөрөл, ачааллыг бууруулсан байна.	Орон нутгийн шилжин ирээгүй хөдөлмөр эрхэлж буй иргэдийн судалгааг гаргаж албан байгуулага, аж ахуй нэгжүүдэд улсын бүртгэлийн хэлтэс болон сумын Засаг даргын албан тоотыг хүргүүлж ажилласнаар 2024 оны эхний хагас жилийн байдлаар суманд 45 албан хаагч, тэдгээрийн хүүхэд 17, нийт 62 иргэн суманд шилжин ирээд байна. Шилжин ирсэн 45 иргэнийг ажиллаж буй салбараар нь ангилвал: ❖ Ерөнхий боловсролын сургуульд 10, “Шивээ-Овоо” ХК-д 15, Сургуулийн өмнөх боловсролд 4, Бусад байгууллагад 16 иргэн ажиллаж, шинээр шилжин ирээд байна. Шинээр шилжин ирж байгаа төрийн албан хаагчдад хөнгөлөлт тусламж үзүүлэх ажлыг төрийн захиргаа, төсвийн байгууллагын удирдлагуудтай хамтран зохион байгуулж байна. Аймгийн ХХҮГ-аас хэрэгжүүлдэг нийтийг хамарсан ажлын хүрээнд түр ажлын байрыг бий болгодог. Эхний хагас жилийн байдлаар нийтийг хамарсан түр ажлын байранд 20 иргэн ажиллаж эхлээд байна. Хүрсэн түвшин: Шинээр ажилд томилогдсон төрийн албан хаагчийн тоо-15 Түр ажлын байр-20	100
ТАВ.НОГООН ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ					
Зорилт 5.1.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад дорвитой хувь нэмэр оруулах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үр дүнтэй өрнүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.					
3.	5.1.1	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарьж, арчилж ургуулах ажлыг нарийвчилсан стратеги, төлөвлөгөөний хүрээнд үр дүнтэй хэрэгжүүлэх	Шинээр тарьж, арчилж ургуулсан мод, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ нэмэгдсэн байна.	2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр сумын нийт төрийн байгууллагууд нийтийн эзэмшлийн талбайн хуваарьт талбайн “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн дагуу таригдсан моднуудын тогоог янзлах, элс шороо хог хаягдлыг хаяж цэвэрлэх, хашааг янзлах зэрэг ажлуудыг хийгээд байна. Мөн байгууллагууд “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн дагуу модны суулгацыг бэлтгэх, усалгаа арчилгаа зэргийг хийж эхлээд байна. Тэрбум үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэхээр 2024	100

				<p>оны хаврын мод, бут тариалалт 5 дугаар сарын 17-оос эхэлсэн бөгөөд эхний байдлаар нийт 9 байгууллага 2295 ширхэг мод бутыг суулгаад байна.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ ЗДТГ-110ш шар хуайс ➢ ИШОНӨААТҮГ-1000ш шар хуайс ➢ 3-р сургууль-600 шар хуайс ➢ 3-р цэцэрлэг200 шар хуайс ➢ Эрүүл мэндийн төв-110 ш шар хуайс, 50ш хайлаас ➢ Нарлаг шивээ СӨХ-20ш хайлаас, 35ш шар хуайс,10ш голт бор ➢ Цагдаагийн хэсэг-30ш шар хуайс ➢ Страто ХХК-100ш хайлаас тариад байна. <p>Хүрсэн түвшин: Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо- 2 Шинээр нэмж тарьсан модны тоо-2295 Ургалтын хувь 80%-тай. Нэмэгдсэн ногоон байгууламж 1.2 га</p>	
Зорилт 5.3.Байгальд ээлтэй дэвшилтэт технологи бүхий хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулна.					
4.	5.3.1	<p>Нийслэл хот болон аймгийн төвүүдэд хог хаягдлыг ангилан ялгах, эх үүсвэр дээр нь бууруулах, дахин боловсруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг дэмжиж, хог боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах</p>	<p>Хог хаягдлын дахин боловсруулалтын хэмжээг 27 хувьд хүргэсэн байна.</p>	<p>Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ний 06 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар сумын төвийн Хуучин хог хаягдлыг булшлах, шинээр хогийн цэг байгуулах ажлын төсөв 235,400,000 төгрөг батлагдсан бөгөөд уг ажлын тендер зарлагдан гүйцэтгэгчийг шалгаруулахаар ажиллаж байна. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний 06 дугаар тогтоолын дагуу Байгаль орчин, эрүүл ахуй, орчны бохирдлыг бууруулах “Хоггүй сум” арга хэмжээний зардлаар туурь хог хаягдалтай 5 га талбайг цэвэрлэхээр 10 сая төгрөгийн төсөв батлагдаад байгаа бөгөөд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна. Тус ажил 06-07 дугаар сард хийгднэ. БОАЖС-н 2023 оны 02 дугаар албан даалгаврын дагуу АБ, ААН-үүдэд байгууллагын төсөвт оруулан тус бүр ангилан ялгах, хогийн савыг байршуулах, ангилан ялган хоёрдогч түүхий эд авах газарт тушаах чиглэлийн хүргүүлсэн. Сумын Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/133 тоот захирамжаар “Хог хаягдал дахин боловсруулах тоног төхөөрөмж худалдан авах” иргэнд 65.0 сая төгрөгийн зээлийг олгож, тус ажлын үйл ажиллагаа жигдэрч, эхний хагас жилийн байдлаар хуванцар сав 2тонн, пивоны лааз 500кг, гялгар уут 180 кг дахивар цуглуулсан байна.</p> <p>Хүрсэн түвшин: “Хог хаягдал дахин боловсруулах тоног төхөөрөмж худалдан авах” иргэнд олгосон зээлийн хэмжээ-65 000 000 төг Зээл олгосон төслийн тоо-1 Шинээр бий болсон ажлын байрны тоо-2 ОНХС-аар хийгдэх 2 ажлын төсвийг батлуулан, тендерийг зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна.</p>	100
ЗУРГАА.ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН СЭРГЭЛТ					

Зорилт 6.1.Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна.					
5.	6.1.1	“Цахим үндэстэн” болох арга хэмжээг эрчимжүүлж, нийтийн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгож, цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим харилцаанд шилжиж, нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг хангаж, цахимаар үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж, тоог нэмэгдүүлж, иргэнийг цахим гарын үсгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр нээлтээ хийсэн төрийн үйлчилгээний нэгдсэн систем болох “E-Mongolia”-д нэвтрүүлсэн төрийн 57 байгууллагын 563 үйлчилгээг 1000-д хүргэн нэмэгдүүлж, цахим гэрээ хэлцлийг байгуулах нөхцөл бүрдэж, иргэд цаг хугацаа, орон зайнаас үл хамаарч төрийн үйлчилгээг шуурхай авах нөхцөл бүрдсэн байна.	<p>Е-Монголиа төрийн цахим үйлчилгээ ХУР ДАН системийн үйлчилгээг эрчимжүүлж иргэдэд тэгш хүртээмжтэй түргэн шуурхай хүргэн ажилласан байна. 2024 оны хагас жилийн байдлаар нийт төрийн цахим үйлчилгээ тоо-485. Үүнээс: олон шатлалт үйлчилгээ-5, лавлагаа-480 гарсан байна. 2024 оны 06 дугаар сард багтаан ХУР-ДАН системийн КИОСК машиныг сумын ЗДТГ-т байршуулахаар ажиллаж байна. Төрийн үйл ажиллагааны дотоод удирдлагын ERP системийг Засаг даргын Тамгын газрын 19 албан хаагчид нэвтрүүлж, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглаж байна. ERP системээр ЗДТГ-т 2024 оны 5-р сарын байдлаар 182 албан бичгийг хүлээн авч бүртгэл хөтлөн, шийдвэрлэн ажилласан. ЗДТГ-аас гадагшаа, бусад албан байгууллагууд руу цахим системээр 62 албан бичгийг илгээсэн байна.</p> <p>Хүрсэн түвшин: ERP системийг нэвтрүүлэлтийн хувь-100% /19/ Албан бичиг хүлээн авсан тоо-182</p> <p>Операторын системээр төрийн үйлчилгээг иргэдэд үйлчилсэн тоо-485</p>	100
Зорилт 6.2.Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтад цогц шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч, оновчтой бүтцийг тогтоон, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлнэ.					
6.	6.2.1	Мэргэжлийн холбоонд эрхээ шилжүүлэн хийлгэх боломжтой төрийн чиг үүргийн талаарх судалгааг салбар бүрээр гаргаж, шилжүүлэх ажлыг үе шаттайгаар эхлүүлэх	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоонд шилжүүлж, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, төрийн албыг цомхон, чадварлаг болгох боломжийг нэмэгдүүлсэн байна.	<p>“Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс суманд Уул уурхайн үйлдвэрлэл, тээвэрлэлт эрхэлдэг 3 аж ахуй нэгжүүдтэй хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний хариуцлагын хүрээнд:</p> <p>2024 он гарснаар сумын хэмжээнд өвөлжилт хаваржилт хүндэрсэнтэй холбоотой сэг зэм устгалын ажил, цасанд боогдсон газруудаар зам гаргах, малчин өрхүүдэд өвс тэжээл тээвэрлэх, тараах ажилд хүн хүч, машин техник бараа материалаар туслалцаа үзүүлэн ажиллаад байна.</p> <ul style="list-style-type: none"> ➢ “Шивээ-Овоо” ХК сэг зэм цуглуулах, зөөх, булж устгах ажилд 5 удаа, ➢ “МАК” ХК зам гаргах, сэг зэм цуглуулж зөөж, булж устгах ажилд 12 удаа, ➢ “Страто” ХХК зам гаргах, сэг зэмийн ажилд 7 удаа тус тус явж ажилласан байна. <p>Мөн “Эйкү сора” ХХК, “Цотан жанжин транс” ХХК-ууд нийгмийн хариуцлагын хүрээнд сумын малчдад өвс тэжээл тараах ажлыг 2 удаа гүйцэтгээд байна.</p> <p>Хүрсэн түвшин: Гэрээ байгуулсан тоо-3 Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвشلээр хийлгэсэн ажлын тоо-36</p>	100

Зорилт 6.3.Төрийн хяналт, шалгалтын давхардсан тогтолцоог цэгцэлж, төлөвлөгөөт шалгалтыг түр хугацаанд зогсоож, төрийн байгууллагаас шаарддаг тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлийн тоог бууруулна.					
7.	6.3.1	Төрийн үйл ажиллагааг ил тод, шуурхай болгох, төрийн хүнд суртлыг арилгах, бизнес эрхлэгчдийг дэмжих тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн тоог 2 дахин цөөрүүлж, цахимаар олгох, сунгах боломжийг бүрдүүлэх	Хуулиар хориглосон, эсхүл зөвшөөрөл шаардахаас бусад төрлийн үйл ажиллагааг хүн, хуулийн этгээд хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхлэх боломжтой болсон байна.	2024 оны эхний хагас жилийн байдлаар тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт ирээгүй байна.	-
Зорилт 6.4.Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна.					
9.	6.4.1	Улаанбаатар хотоос бусад орон нутагт ажиллах төрийн албан хаагч Төрийн албаны тухай хуульд заасан ажилласан жилийг тогтоосон тусгай шаардлагын 50 хувийг хангасан бол хугацаанаас өмнө шатлан дэвшүүлэх	Төвлөрлийг сааруулах, ажиллах хүчний эрэлтийг хангасан байна.	<p>Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд орон нутагт шилжин ирээгүй хөдөлмөр эрхэлж буй иргэдийн судалгааг гаргаж албан байгуулага, аж ахуй нэгжүүдэд улсын бүртгэлийн хэлтэс болон сумын Засаг даргын албан тоотыг хүргүүлж ажилласнаар 2024 оны эхний хагас жилийн байдлаар суманд 45 албан хаагч, тэдгээрийн хүүхэд 17, нийт 62 иргэн суманд шилжин ирээд байна. Шилжин ирсэн 45 иргэнийг ажиллаж буй салбараар нь ангилвал:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Ерөнхий боловсролын сургуульд 10, “Шивээ-Овоо” ХК-д 15, Сургуулийн өмнөх боловсролд 4, Бусад байгууллагад 16 иргэн ажиллаж, шинээр шилжин ирээд байна. <p>Шинээр шилжин ирж байгаа төрийн албан хаагчдад хөнгөлөлт тусламж үзүүлэх ажлыг төрийн захиргаа, төсвийн байгууллагын удирдлагуудтай хамтран зохион байгуулж байна. Аймгийн ХХҮГ-аас хэрэгжүүлдэг нийтийг хамарсан ажлын хүрээнд түр ажлын байрыг бий болгодог. Эхний хагас жилийн байдлаар нийтийг хамарсан түр ажлын байранд 20 иргэн ажиллаж эхлээд байна. Мөн Орон нутагт шаардлагатай мэргэжлээр шилжиж ажиллах нарийн мэргэжлийн хүний нөөц, бусад албан хаагчдыг ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлж, санхүүгийн болон орон байрны дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд 2024 оны эхний хагас жилийн байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Эрүүл мэндийн төв-Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хөдөө орон нутагт шилжин суурьшиж ажиллахаар ирсэн багийн эмчийн нийгмийн баталгааг хангах үүднээс орон нутагт ажиллах нөхцлийг бүрдүүлэн, түрээслэн амьдарч буй байрны түрээсийн төлбөрийг зургаан сарын хугацаагаар төлөөд байна. ➢ Ерөнхий боловсролын сургууль- Шивээговь сумын Засаг даргын Тамгын газрын 2 өрөө байранд бага ангийн 1 багш, англи хэлний 1 багш нар амьдарч байна. <p>Хүрсэн түвшин: Шинээр ажилд томилогдсон төрийн албан хаагчийн тоо-15 Түр ажлын байр-20 Орон байраар хангагдсан албан хаагчийн тоо-3</p>	100
Дундаж биелэлт					93.3

№	БОДЛОГЫН ЗОРИЛТЫН НЭР	Арга хэмжээний тоо	Дундаж үнэлгээний хувь
1.	ДӨРӨВ.ХОТ, ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ	2	70
2.	ТАВ.НОГООН ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ	2	100
3.	ЗУРГАА.ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН СЭРГЭЛТ	4	100
ДҮГНЭЛТ	Нийт 3 бодлогын 9 арга хэмжээний ерөнхий дундаж үнэлгээ	9	100

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН
МЭРГЭЖИЛТЭН

М.ГАНТУЯА

ХЯНАСАН:

ТАМГЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ